

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН 14 МЕГА ТӨСЛҮҮДИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн удирдлагын тогтолцоо

Засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэх үүднээс хамтарсан Засгийн газрын “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээг удирдлага болгон нийгэм, эдийн засаг, ардчилал, бүсчилсэн хөгжлийн бодлогын үндсэн дөрвөн чиглэлийг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Тэргүүлэх чиглэлийн эдгээр төслүүд хэрэгжсэнээр экспортын орлогыг хоёр дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадлыг гурав дахин, импортыг орлох экспортын бүтээгдэхүүн хөгжүүлж олон улсын зах зээлд өрсөлдөх, шинээр бий болох ажлын байрны тоог нэмэгдүүлэх замаар бүс нутгийн хөгжилд ахиц дэвшил гарах томоохон бүтээн байгуулалтууд бий болох ба төслүүдийн харилцан хамаарал, эрчим хүч болон усны хэрэгцээ шаардлагыг хангах төслүүдийн үр дүнд эрчим хүчний эх үүсвэрийн хомсдолоос гарч эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдэж, Монгол улсын эдийн засаг, нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт гарч, эерэг нөлөөг авчирна гэж тооцсон.

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан бөгөөд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 бодлогын чиглэлийн хүрээнд 16 зорилго, 62 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 593 үйл ажиллагааг тусгалаа.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан УИХ-ийн гишүүд, яамдаас санал авч 196.9 их наяд төгрөгийн 1,540 төсөл, арга хэмжээг тусган нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар батлуулсан.

2. Тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эдийн засгийн голлох үзүүлэлт болох ДНБ-ийг 10,000 ам.долларт хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6 хувь болгохыг зорьж, эдийн засгийн суурийг тэлэх 14 мега төсөл, үндэсний бүтээмжийг нэмэгдүүлэх 14 реформ, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 тэргүүлэх төсөл, арга хэмжээг тусгасан.

3. Хөгжлийн төслүүдийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд

Урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд тус яамнаас шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Тухайн жилийн төсвийн тухай хуульд Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын багцад туссан төсөл, арга хэмжээ, төсөвт өртгийн хүрээнд тухайн жилд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалтын жагсаалтыг баталдаг.

Энэхүү жагсаалтыг боловсруулахдаа Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, санхүүжилтийн эх үүсвэрийг хувийн хэвшлээр болон бусад эх үүсвэрээс санхүүжих боломж зэрэг үндсэн шалгуураас гадна бусад төсөвт өртөг, урсгал зардал нэмэгдүүлэх эсэх, газрын асуудал зэрэг шалгуурыг хангаж буй эсэхээр үнэлж эрэмбэлэн, сонгон шалгаруулалт хийдэг.

4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын их хуралд өргөн мэдүүлж, 2022 оны 12 дугаар 09-ний өдрийн Улсын их хурлын нэгдсэн чуулганаар эцэслэн баталсан бөгөөд 2024 оны 01 дүгээр 01-ний өдрөөс тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. Тус хуулийн хүрээнд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтад тулгуурлан урт хугацааны гэрээний дагуу түншлэлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Улсын Их Хурлаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, Нийслэл болон улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй, эсхүл 100,000 түүнээс дээш хүн амтай аймгууд бие даан түншлэлийн төслийг тодорхой салбарт хэрэгжүүлэх боломжтой болсон.

Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох үүднээс нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан Улсын их хуралд өргөн барьж, 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр батлуулсан. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд төслийн урьдчилсан үнэлгээ хийхтэй холбоотой үйл ажиллагаа, холбогдох байгууллагын чиг үүргийг ойлгомжтой болгож, бүрэн шинжилгээ болон сонгон шалгаруулалтын зохион байгуулалтыг оновчтой болгосон бөгөөд хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах үйл ажиллагаа, төслийн бэлтгэл ажлын төлбөр, түншлэлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хувийн хэвшлийн түншлэгчийн эзэмшилтэй холбоотой зохицуулалтуудыг тодорхой болгож тусгасан.

Ийнхүү өнгөрсөн хугацаанд төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг зохицуулж байсан Концессын тухай хуулийг хүчингүй болгон олон улсын жишигт нийцсэн, Концессын тухай хуулийн зарим хийдэл, сул талыг засан сайжруулсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг зохицуулсан шинэ эрх зүйн орчин бүрдэж, эрх зүйн орчны бэлэн байдал бүрэн хангагдаад байна.

МЕГА ТӨСЛҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

2. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 3150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүс нутгийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. "Оюутолгой" ХХК-ийн Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортолж байгаа 110-120 сая ам. долларын валютын төлбөрийг хэмнэнэ.

3. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2027 оноос эхлэн 100 хувь найдвартай, тасралтгүй хангах боломж бүрдэж, 52000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4430 аж ахуйн нэгж, 5400 орон сууц, 36000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.

4. Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станцыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. Оросын Холбооны 1 / 32 Улсад жил бүр төлдөг 25 сая ам. долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438.7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна. 5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.

5. Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ. Монгол Улс нь судалгаагаар 2600 ГВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж байгаа дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.

6. Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолойг барих төслийг хэрэгжүүлнэ. Хэрлэн голын олон жилийн дундаж урсцын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мянган тонн хүлэмжийн хийг бууруулна. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна. Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны түвшин тогтворжиж, Онги голын дагууд оршин сууж байгаа 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.

7. Эрэнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг бууруулна.

8. Монгол, Францын хамтарсан Ураны төслийг хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжиж, үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажилласнаар жилд 2500 тонн ураныг олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улсын болон орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам. долларын татвар төлнө. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон худалдан авалт, бизнесийн боломж нэмэгдэнэ. Монгол Улсад атомын цахилгаан станцыг барих суурь судалгааг хийнэ.

9. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ. Кокс-химийн үйлдвэрийн нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн /мидлинг/ үйлдвэрлэнэ. Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулснаар 140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн зэрэг дагалдах үйлдвэрүүд бүхий жилд 500 мянган тонн ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.

10. Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам. долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

11. Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.

12. Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

13. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. Тус төсөл хэрэгжсэнээр жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

14. Үндэсний хиймэл дагуулыг хөөргөнө. Монгол орны нийт газар нутгийн 26.8 хувьд 4G сүлжээ нэвтэрсэн. Үлдсэн 73.2 хувь буюу орон нутгийн иргэд, малчин айл өрхийг шилэн кабелиар интернэт сүлжээнд холбоход шаардлагатай 29.0 их наяд төгрөгийг хэмнэж, улс орны өнцөг булан бүрд интернэтийн сүлжээ нэвтэрнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед 2 / 32 газрын сүлжээнд саад, доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

1. ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ

Төслийн үндэслэл:

“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Хятадын зураг төслийн групп” компани нар 2023.05.26-ны өдөр гэрээ байгуулан Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан өргөн, нарийн царигийн төмөр замын шугамын чигийг тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол, 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн “1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоол, Засгийн газрын 310 дугаар тогтоол зэрэг шийдвэрүүдийг тус тус үндэслэн, Монгол, Хятадын “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан.

Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг холбох төмөр зам нь I зэрэглэлийн, гол замын урт 19.5 км /дэлгэмэл урт 32.6 км/ үүнээс өргөн /1520мм/ царигийн 8.7 км /дэлгэмэл уртаар 12.1 км/, нарийн /1435мм/ царигийн 10.8 км /дэлгэмэл уртаар 20.5 км/ бөгөөд уг төмөр зам ашиглалтад орсноор жилд 30-50 сая.тн нүүрс жилд тээвэрлэх хүчин чадалтай болно. Уг төмөр замын ашиглалтад оруулснаар Монгол - Хятадын хилийн төмөр замын хоёр дахь шинэ гарцтай болно.

Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын техникийн үзүүлэлт:

Үзүүлэлт	Өргөн цариг	Нарийн цариг
Төмөр замын зэрэглэл	I зэрэглэл	
Цариг	1520мм	1435мм
Нэг голын даралт	25тн	
Гол замын тоо	Нэг замтай	
Гол замын урт	8.7км	10.8км
Дэлгэмэл урт	12.1	20.5
Гүүрийн урт /9.5км/	Хос замтай гүүр 1.46км	
	Дан зам 4.3км	Дан зам 3.8км
Тооцоот хурд	100-120км/цаг	
Удирдах хэвгий	6‰	6‰ / 11‰
Татах төрөл	Дотоод шаталтат, цахилгаанжуулах боломжтой	
Зүтгүүрийн төрөл	АНУ-ын SD70Ace/lw	HXN
Хүлээн авах явуулах замын ашигтай урт	1700м	1050м
Хориглолын төрөл	Өртөө хооронд хагас автомат	

Төслийн хэрэгжилтийн явц:

“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Хятадын зураг төслийн групп” компани нар 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулан Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж бүрэн дууссан.

Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан өргөн, нарийн царигийн төмөр замын шугамын чигийг тогтоон баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны “1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын хүрээнд Засгийн газрын 2024 оны 310 дугаар тогтоол батлагдсан.

Мөн 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Монгол, Хятадын “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дугаар сарын 16-ны өдрийн 59 дугаар захирамжаар “1955 оны “Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.

Уг ажлын хэсэг шинэчлэн байгуулагдаад 2 удаа БНХАУ-ын талтай очиж уулзсан. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болон ажиглагч орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд оролцоод буцах замдаа 2024.10.18-нд БНХАУ-д “Чайна Энержи” группийн ТУЗ-ийн дарга Люй Гуоюэ-тэй уулзсан. Хил холболтын бүтээн байгуулалт болон гүүр барих ажлыг эрчимжүүлэх саналтай байгаагаа Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ илэрхийлсэн.

Хил дамнасан төмөр замын төсөл амжилттай хэрэгжснээр Өмнөговь аймгийн уул уурхай, дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүд эргэлтэд орж хөдөлмөр, бараа бүтээгдэхүүн, технологи, инноваци, бизнес, нийгэм соёлын харилцаа болоод хөдөлгөөн идэвхижиж, тус аймаг Өмнөд бүс нутгийн уул уурхай, тээвэр логистик, хөгжлийн томоохон төв болно.

1.2 ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ

Шивээхүрэн-Сэхээ боомтын /гол замын урт 6.9 км/ төмөр замын суурь бүтцийг барьж байгуулснаар Нарийнсухайтын орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн экспортод гаргах шинэ хилийн гарц нээгдэж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 10 сая тонноор нэмэгдэнэ. Монгол Улсын төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх, дотоодын төмөр замын сүлжээг нэмэгдүүлэх, хилийн боомтын шинэ гарц бий болгох, уул, уурхай бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр замын барилгын ажил 1 жилийн хугацаанд өөрийн хөрөнгө оруулалтаар “Нарийн сухайтын төмөр зам” ХХК гүйцэтгэсэн.

Ач холбогдол:

- Монгол Улсын экспортын бүтээгдэхүүн БНХАУ-ын нутгаар дамжин далайн чанд дахь зах зээлд хүрэх шинэ гарцыг бий болгоно.
- Өнөөгийн экспортын тээврийн хэмжээг 10 сая.тн-оос 30 сая.тн хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Бүс нутаг болон төмөр замын тээвэрлэлтээс улсын төсвийн өнөөгийн орлогыг 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой болно.
- Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нүүрсний тээврийн зардлыг 2.5-4 дахин бууруулна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж шинээр 233 хүнийг ажлын байраар хангана.
- “Нарийнсухайт төмөр зам” ХХК нь өөрийн хөрөнгөөр буюу нийт **207,667,090,853** төгрөгний хөрөнгө оруулж тус бүтээн байгуулалтыг барьж байгуулсан.

Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр зам нь II зэрэглэлийн, нарийн /1435мм/ царигтай, 19.2км дэлгэмэл урттай, хагас автомат төвлөрүүлэлттэй, хүлээн авах явуулах 5 замтай, ачилт буулгалтын 4 замтай, 10 сая тонн ачааг тээх нэвтрүүлэх хүчин чадалтай юм.

Шивээхүрэн-Сэхээ хил дамнасан төмөр замын техникийн үзүүлэлт:

Байршил	Өмнөговь аймаг, Гурвантэс сум
Гол замын урт	6.9км
Дэлгэмэл урт	19.2км
Өртөө	1
Замын зэрэглэл	II зэрэглэл, уулзвартай зам
Голын даац	25 тонн
Тээвэрлэлтийн хүчин чадал	10 сая тонн /жил/
Цариг	1435мм
Дохиолол холбоо	Хагас автомат
Хүлээн авах явуулах зам	5 замтай
Ачилт буулгалтын зам	4 зам, чингэлэг терминалын талбайтай
Замын дээд бүтэц	ТВ60 маркийн зам төмөртэй, буталмал чулуун чигжээстэй

1.3 ХАНГИ-МАНДАЛ БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын А/299 дугаар тушаалаар байгуулагдсан Техникийн комисс 2023 оны 01-ны өдрийн 16-19-ний өдрийн хооронд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дээд, доод бүтцийн барилгын ажлын нийт гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, үүрэг даалгавар өгсөн. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар 2023 оны эхнээс зүгшрүүлэх тээвэрлэлт эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд Ханги-Мандал хил дамнасан олон төрөлт чингэлэг тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх юм.

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын техникийн үзүүлэлт:

Байршил	Дорноговь аймаг, Мандах, Зүүнбаян, Хөвсгөл, Хатанбулаг сум
Гол замын урт	226.9км
Дэлгэмэл урт	347.6км
Өртөө	2 өртөө, 6 зөрлөгтэй
Замын зэрэглэл	III зэрэглэл, уулзвартай зам
Голын даац	25 тонн
Тээвэрлэлтийн хүчин чадал	20 сая тонн /жил/
Цариг	1520мм
Дохиолол холбоо	Хагас автомат
Хиймэл байгууламж	4 гүүр, 235 хоолой
Замын дээд бүтэц	ТВ60 маркийн зам төмөртэй, буталмал чулуун чигжээстэй

Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр замын төсөл хэрэгжсэнээр Тавантолгой – Ханги чиглэлд нүүрсний экспорт жилд 13-15 сая тонноор нэмэгдэж, нийтдээ уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ жилд 20-25 сая тоннд хүрэх боломжтой болно. Улаанбаатар төмөр замын Замын-Үүд- Эрээн боомтоор нэвтэрч буй ачаа тээврийн ачааллыг бууруулж, экспорт болон транзит тээврийн урсгалыг нэмэгдүүлнэ.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугатын аж үйлдвэрийн бүсэд зориулан экспортлох уул уурхайн бүтээгдэхүүнийг өнөөгийн байдлаар Замын-Үүд – Эрээн – Жинин – Хөх хот – Бугат чиглэлийн төмөр замаар тээвэрлэж байгаа бөгөөд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар тээвэрлэхэд энэхүү зайг 318 км-ээр дөт болгох давуу талтай юм.

Төслийн хэрэгжилтийн явц:

“Монголиантранс лайн” ХХК болон “Монголиантранс ложистик” ХХК-уудын нэгдэл 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл”-ийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх /DBOT/ концессын гэрээг байгуулж 226.9км төмөр замыг барьж байгуулсан.

2023 оны 2-р сараас нүүрсний экспортын тээврийг эхлүүлсэн бөгөөд одоогоор нийт 1,22 сая тн тээвэрлээд байна.

- Монгол, Хятадын хилийн Ханги-Мандал боомтыг “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” 2004 оны Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмж тусгах.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр 33.5 га талбайд хэрэгжих энэхүү төслийн хүчин чадал нь эхний шатанд жилд 12 сая тн, төслийн дараагийн шатанд жилд 18 сая тн нүүрс хилээр нэвтрүүлэх бөгөөд дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

- Ачаатай чингэлгийг автомат удирдлагатай, ухаалаг тээврийн хэрэгсэл болон агаарын чингэлэг тээврээр хил дамнуулан тээвэрлэлтийг өдрийн 24 цаг, жилийн 365 хоногт тасралтгүй хийх боломжтой.
- Ханги болон Мандал боомтын ачаа тээврийн терминал хооронд автомат удирдлагатай, ухаалаг тээврийн хэрэгсэлд зориулсан автозам болон агаарын төмөр замаар холбон чингэлэгийг хүний оролцоогүй, алсын удирдлагаар, тасралтгүй тээвэрлэх боломжтой.
- Хүнээс үл хамаарах тээвэр зохион байгуулалт хийх боломж бүрдсэнээр цар тахлын үед ч тасралтгүй экспортыг зохион байгуулж, эдийн засгийн хүндрэлийг даван туулах нөхцөл бүрдэнэ.
- Уурхайн амнаас эцсийн хэрэглэгч хүртэл битүүмжилсэн чингэлэг тээвэрлэлт хийгдэх боломж бүрдэнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний чанар, чийгшлийн алдагдал эрс буурна.
- Нийт тээвэрлэлтийн явцад үүсэх хорогдол эрс багасна. Өнөөгийн тээвэрлэлтийн үйл явцад 15%-ийн хорогдол үүсдэг.
- Ухаалаг систем нэвтрүүлсэнээр тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдаж бүхэлдээ оролцогч талуудын хяналтанд орж итгэлцэл бий болно.
- Хил, гаалийн бүрдүүлэлт хурдан шуурхай болно.
- Чингэлгээр тээвэрлэлт хийхэд автомашины сул зогсолт үгүй болон урт дараалал арилж, боомтын тээврийн бүтээмж нэмэгдэнэ.
- Ачилт, буулгалт, тээвэрлэлтийн явцад үүсэх тоосжилтын жолоочид үзүүлэх хор нөлөө арилснаар эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүрдэнэ.
- Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө эрс буурна.
- Цаашид биржийн арилжаа зохион байгуулагдах анхдагч нөхцөл бүрдэнэ.

Эдгээр нь хилийн боомтын төмөр замын ачаа тээвэрлэлтийг хурдасгаж хоёр орны хоорондох худалдаа, тээвэрлэлтийн урсгалыг сайжруулах, зардлыг бууруулах, аялал жуулчлал, бизнесийн болон соёлын солилцоог хөгжүүлэх зэрэг хоёр орны эдийн засагт чухал ач холбогдолтой байхын хамт орон нутгийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн боловсрол, амьдралын чанарыг дээшлүүлэх, байгаль орчны сайн менежментийг нэвтрүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн олон эерэг өөрчлөлтүүдийг авчирна гэж тооцож байна.

Эдгээр төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

2. ЧОЙБАЛСАН-БИЧИГТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ

Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр зам нь Дорнод, Сүхбаатар аймгуудын нутгаар дамжин өнгөрөх бөгөөд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Эрээнцав-Чойбалсан чиглэлийн 238 км төмөр замтай холбогдоно.

Ач холбогдол:

- Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор экспортын хэмжээ 20-25 сая тонноор нэмэгдэнэ.
- Бичигт-Эрээнцав чиглэлийн төмөр замын коридор нь Орос, Хятадыг холбосон төмөр замаас даруй 500 км-р богино бөгөөд тонн тутмаас 12 ам.доллар хэмнэх боломжтой.
- Зүүн бүсийн төмөр зам баригдсанаар олон ордуудын нөөцийн ангилал нь геологийн нөөцөөс эдийн засгийн үр ашигтай нөөцийн ангилал руу шилжиж бүс нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах боломжтой юм.
- Монгол Улсаар дамжин өнгөрөх экспортын хэмжээ нэмэгдэж, Европ-Азийг холбосон транзит тээврийн шинэ гарц бий болж, эдийн засагт онцгой ач холбогдол үзүүлнэ.
- БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын шинэ гарцуудыг бий болгож эцсийн хэрэглэгчид шууд хүргэнэ.
- Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын төслийн суурь бүтцийн бүтээн байгуулалтын төсөвт өртөг урьдчилсан тооцооллоор 7.4 их наяд төгрөг бөгөөд төсөвт өртгийн бодит дүн нарийвчилсан зураг төслийн дараа эцэслэн тогтоогдоно.

Чойбалсан-Хөөт-Бичигт техникийн хүчин чадал:

Байршил	Дорнод, Сүхбаатар аймгийн нутгаар дамжин өнгөрнө.
Гол замын урт	Чойбалсан-Хөөт-193км, Хөөт-Бичигт-222км Нийт-415км
Дэлгэмэл урт	ТЭЗҮ-ээр тодорхойлогдоно.
Өртөө	7өртөө, зөрлөгтэй /ТЭЗҮ-ээр эцэслэн тодорхойлогдоно./
Замын зэрэглэл	III зэрэглэл, уулзвартай зам
Голын даац	25 тонн
Тээвэрлэлтийн хүчин чадал	12-15сая тонн /жил/
Цариг	1520мм
Дохиолол холбоо	Хагас автомат
Хиймэл байгууламж	29ш гүүр, 181ш хоолой
Замын дээд бүтэц	P65, TB60 маркийн зам төмөртэй, төмөрбетон дэртэй, буталмал чулуун чигжээстэй

Төслийн хэрэгжилтийн явц:

“Чойбалсан - Бичигт” чиглэлийн төмөр замын төслийн Техник-Эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК болон “Ниппон коей” компаниудын 2013 оны 02 дугаар сард хийсэн “Монгол Улсын шинэ төмөр замын төслийн техникийн зөвлөгөө өгөх үйлчилгээ-зураг төслийн тайлан”-г орчуулж ТЭЗҮ-г боловсруулахаар ажиллаж байна.

Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам барих төсөл нь Монгол Улсын төмөр замын сүлжээг өргөжүүлж, олон улсын тээвэр, худалдааг хөнгөвчлөх зорилготойгоор хэрэгжиж буй томоохон дэд бүтцийн төсөл бөгөөд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тээврийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх зорилготой, томоохон стратегийн ач холбогдолтой юм.

Нийгмийн хөгжлийн нөлөө

- Нийгмийн хөтөлбөрүүдийг дэмжинэ: Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор орон нутгийн иргэдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний хангамж сайжирч болно.
- Хөдөлмөрийн ур чадварыг нэмэгдүүлнэ: Төмөр замын барилга, засвар үйлчилгээ, ашиглалтад орсноор тухайн бүс нутагт инженер, ажилчид болон тээврийн үйлчилгээний салбарт ур чадварын сайжруулалт явагдана.

Бүс нутгийн хөгжлийг дэмжих

- Хот суурин газар хөгжинэ: Төмөр замын замын дагуу шинэ суурин газрууд, бизнесүүдийн төвүүд байгуулагдаж, хүн амын төвлөрөл нэмэгдэх болно.
- Аж үйлдвэрийн хөгжил: Тээвэрлэлтийн хурдацтай өсөлт нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэгтэй түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд боломжийг нээнэ. Энэ нь орон нутгийн жижиг дунд үйлдвэрүүдийн хөгжилд хувь нэмэр оруулна.
- Аялал жуулчлал нэмэгдэнэ: Замтай холбоотойгоор шинэ аялал жуулчлалын чиглэлүүд бий болж, тухайн орон нутагт аялал жуулчлалын хөгжил нэмэгдэх магадлалтай.

Соёл, уламжлал, хэл соёлын нөлөө

- Нийгмийн харилцаа сайжирна: Орон нутгийн иргэдийн хооронд шууд харилцаа сайжирч, соёл, хэлний хувьд шинэ санаачилгууд, орон нутгийн баялагийг хадгалахад ихээхэн нөлөө үзүүлнэ.
- Төрийн бодлогын дэмжлэг нэмэгдэнэ: Засгийн газраас орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлснээр үндэсний соёл, уламжлалыг хадгалан хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Дэд бүтэц, технологийн шинэчлэл

- Дэд бүтэц сайжирна: Төмөр зам баригдсанаар зам, гүүр, усан хангамж, цахилгаан зэрэг дэд бүтцийн шинэчлэл хийнэ. Энэ нь орон нутгийн хөгжилд шууд нөлөө үзүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- Технологийн шилжилт хийгдэнэ: Төмөр замын төсөл нь орон нутагт шинэ технологи, техник хэрэгсэл, бүтээмжийг нэвтрүүлж, технологийн шилжилт хийхэд тустай.

Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам нь орон нутгийн эдийн засгийн өсөлт, тээврийн хурдасгал, нийгмийн хөгжилд нөлөөлөх ч байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тооцон нягтлан бодох хэрэгтэй. Төслийг зөв төлөвлөж, бүх талын ашиг сонирхлыг зохистой хослуулах нь орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, цаашдын нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх юм.

3. “ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Төслийн явц:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 160 дугаар тогтоолоор “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн санхүүжилтийг БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Сангийн яам болон БНХАУ-ын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн дагуу төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Пауэр Чайна-Пауэр Чайна Чэнгду” компанийн түншлэл шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулахад шаардлагатай баримт бичгийн бүрдлийг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр БНХАУ-ын Экспорт-Импорт банканд хүргүүлснээр банкны зээлийн судалгаа буюу төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулах бэлтгэл ажил эхэлж, 2023 оны 03 дугаар сарын сүүлээр тус банкны төлөөлөл төслийн талбарт ирж ажилласнаар төслийн үнэлгээний ажил эцэслэгдэж, эрчим хүчний яамны зүгээс 2023 оны 05 дугаар сард холбогдох бүх тайлбар мэдээлэл, мэргэжлийн байгууллагын зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлж дууссан.

Төсөлд хийгдэх гол ажлууд:

- 2025 онд - Зураг төсөл боловсруулах болон магадлал хийх;
Барилга угсралтын ажилд зориулсан түр байгууламжууд;
Голын урсгалыг шилжүүлэх болон түр боомтын ажил;
Боомт (Ероолын ус гаргуур ба хаяур, Ус хүлээн авах дамжуулах туннел болон даралтат тэнцвэржүүлэх сав, түрэлтэт хоолой, станцын барилга болон ус хаях суваг).
- 2026 онд - Голын урсгалыг шилжүүлэх болон түр боомтын ажил;
Боомт (Ероолын ус гаргуур ба хаяур, ус хүлээн авах дамжуулах туннел болон даралтат тэнцвэржүүлэх сав, түрэлтэт хоолой, станцын барилга болон ус хаях суваг);
Ховд хот дахь ажилчдын оффис, орон сууц.
- 2027 онд - Ажлын талбайд дахь зам болон гүүр;
Голын урсгалыг шилжүүлэх болон түр боомтын ажлын үргэлжлэл;
Боомтын ажлын үргэлжлэл (Ероолын ус гаргуур ба хаяур, ус хүлээн авах дамжуулах туннел болон даралтат тэнцвэржүүлэх сав, түрэлтэт хоолой, станцын барилга болон ус хаях суваг);
Гидро-механик тоног төхөөрөмж суурилуулах (хаалтууд болон өргөх төхөөрөмжийн суурилуулах ажлууд).

- 2028 онд - Боомтын ажлын үргэлжлэл (Ероолын ус гаргуур ба хаюур, ус хүлээн авах дамжуулах туннел болон даралтат тэнцвэржүүлэх сав, түрэлтэт хоолой, станцын барилга болон ус хаях суваг);
- Дэд станц (хувиарлах байгууламж);
- Цахилгаан механик тоног төхөөрөмж суурилуулах (Турбин болон генератор, туслах тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж);
- Түрэлтэт хоолойн барилга угсралтын ажил.
- 2029 онд - Боомтын ажлын үргэлжлэл (Ус хүлээн авах дамжуулах туннел болон даралтат тэнцвэржүүлэх сав);
- Цахилгаан механик тоног төхөөрөмж суурилуулах (туслах тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж);
- Туршилтаар ажилуулах;
- Техникийн сургалт;
- Байнгын ажиллагсдын орон сууц.

Төслийн ач холбогдол:

Төслийн барилга угсралтын шатанд:

- Давхардсан тоогоор 800-1000 хүний ажлын байр бий болно.
- Тухайн бүс нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааг дэмжинэ.

Төсөл ашиглалтад орсны дараа:

- Усан сан үүсгэснээр 1,14 тэрбум м³ хэмжээний цэвэр усны нөөц бүрдэж, жилд 366 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ.
- Баруун бүсийн аймгууд импортын цахилгаан эрчим хүчний хараат байдлаас гарна.
- Хүлэмжийн хийг жилд ойролцоогоор 756.6 мянган тонн нүүрс шатаасантай тэнцэх хэмжээний 1.3 сая тонн нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулна.
- Ашиглалтад орсны дараа 60-80 ажлын байр шинээр бий болно.
- Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Ховд, Буянт сумдад усалгаатай газар тариалан, загасны аж ахуй хөгжүүлэх бүсийг бий болгоно.
- Усан цахилгаан станц бол дэлхийн хамгийн найдвартай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр юм. Нар, салхины цахилгаан станц нь байгаль цаг уураас хамааран үйлдвэрлэл нь хэлбэлздэг бол усан цахилгаан станц нь усыг хуримтлуулан хэрэгцээтэй үед цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжтой.
- Усан цахилгаан станц нь 60-100 жил ашиглагдах ба мөн шаардлагатай урсгал засваруудын цаг хугацаанд нь хийснээр түүнээс дээш жил ашиглагдах боломжтой нь байдаг.

4. “ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Төслийн явц:

ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооны 46 дугаар хуралдаан Энэтхэг Улсад 2024 оны 07 дугаар сард зохион байгуулагдсан бөгөөд тус хуралдаанаас Монгол Улстай холбоотой “**Сэлэнгэ мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт усан цахилгаан станц барих төслүүд**” Монгол Улс саяхан усан цахилгаан станцын хоёр төслөө зогсоохоор шийдсэн бол гурав дахь төсөл болох Эгийн голын усан цахилгаан станцын төслийг үргэлжлүүлэхээр ажиллаж байна. Гишүүн Монгол Улсын Засгийн газар уг төслийн Сэлэнгэ мөрний ус хурах талбай болон өвийн хүрээнд багтаж буй түүний дельтад үзүүлэх нөлөөллийг үнэлэх зорилгоор олон улсын стандартын шаардлагад нийцсэн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахаар зорьж байна.” гэсэн шийдвэрийн төсөл батлагдсан.

Төсөлд хийгдэх гол ажлууд:

2025 онд - Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, туслах далангийн ТЭЗҮ болон үндсэн ТЭЗҮ-ийн нэмэлт судалгааг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, судалгааны ажлуудыг эхлүүлэх;

ОХУ-ын талтай нэгдсэн ойлголцолд хүрэхээр судалгааны ажлыг эхлүүлэх.

2026 онд - ОХУ-ын талтай нэгдсэн ойлголцолд хүрсэн байна.

Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг эцэслэн.

2027 онд - Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг Дэлхийн өвийн хороонд хүргүүлж холбогдох шийдвэрийг гаргуулна.

2028 онд - Төслийн санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэх.

Төслийн ач холбогдол:

Төслийн барилга угсралтын шатанд:

- Давхардсан тоогоор 3000 хүний ажлын байр бий болно.
- Тухайн бүс нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааг дэмжинэ.

Төсөл ашиглалтад орсны дараа:

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд горим тохируулгын эх үүсвэр бий болно.
- Усан сан үүсгэснээр 5.7 тэрбум м³ хэмжээний цэвэр усны нөөц бүрдэж, жилд 606 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ.
- Оргил ачааллын үед импортыг орлож бүс нутгийн эрчим хүчний хараат байдлыг шийднэ.
- ОХУ-д жил бүр төлдөг 45-50 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ.
- Ашиглалтад орсны дараа 150 ажлын байр шинээр бий болно.
- Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна.

5. “СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ БА ТАРХМАЛ ЭХ ҮҮСВЭР БАРИХ”-ТӨСЛИЙН ТУХАЙ

Төслийн тухай:

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан сонгон шалгаруулалтаар нийт 200 МВт нарны цахилгаан станц, нийт 300 МВт-ын салхин цахилгаан станцын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эрчим хүчний яам Дэлхийн банкны Олон улсын санхүүгийн корпорацтай Монгол Улсад салхин цахилгаан станцын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг хамтран хэрэгжүүлэх “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр байгуулсан. Олон улсын санхүүгийн корпораци, түүний зөвлөх баг нь Монгол Улсад 100 МВт орчим хүчин чадалтай салхин цахилгаан станцын барихад шаардлагатай олон улсын жишигт нийцсэн судалгаа болон баримт бичгүүдийг бэлтгэн Эрчим хүчний яаманд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана. Гэрээг байгуулснаар төслийг бодитой хэрэгжүүлэхэд дараагийн шатны ажлууд болох техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, салхины 12 сарын хэмжилт болон байгаль орчин, нийгмийн нарийвчилсан судалгаа, тендерийн бичиг баримтыг бэлтгэх, тендерийн үйл явцыг зохион байгуулж, шалгаруулах зэрэг ажлууд хийгдэнэ. Өнөөгийн байдлаар төслийг хэрэгжүүлэх газрын асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах болон Олон улсын санхүүгийн корпораци зөвлөхийн сонгон шалгаруулалтыг дотооддоо зохион байгуулж байна.

“Нарны цахилгаан станцын төсөл”-ийн төслийг өрсөлдөөнт худалдан авалтын аргаар зохион байгуулахаар “Европын сэргээн босголтын банк”-тай хамтран ажиллаж нэгдсэн сүлжээнд холбох оновчтой байршлыг тогтоон, холбогдох ажлуудыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнд нарны цахилгаан станцыг тархмал байдлаар хэрэгжүүлэх боломжтой үр дүн гарсан. Нарны эх үүсвэрийг нийт бүс нутгийн хэмжээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд цахилгаан дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадвар, системийн шингээх боломжийн талаарх судалгааг “ДҮТ” ТӨХХК-тай хамтран боловсруулж байна. Тус тооцоо, судалгааны үр дүнд үндэслэн төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба төслийг сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Төсөлд хийгдэх гол ажлууд:

2025 онд	-Өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэх нар, салхин цахилгаан станцын төслийн агуулга цар хүрээг тодорхойлох
2026 онд	-Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт зохион байгуулах баримт бичиг бэлтгэх, тендер зарлан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах -ТЭЗҮ боловсруулах, байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээ, -Тендерийн баримт бичиг бэлтгэх, тендер зарлах
2027 онд	-Гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлэх -Салхин цахилгаан станцын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж барилга угсралтын ажлыг эхлүүлэх -Нарны цахилгаан станцын гүйцэгчтэй гэрээ байгуулж эхний ээлжийг ашиглалтад хүлээн авах
2028 онд	- Нар, салхин цахилгаан станцуудын барилга угсралтын ажлыг бүрэн дуусган ашиглалтад хүлээн авах

Тус төслийн ач холбогдол:

- Салхин цахилгаан станцад дунджаар 60-80 байнгын ажлын байр, нарны цахилгаан станцад дунджаар байнгын 50-90 ажлын байр буюу нийт 110-170 ажлын байр шинээр бий болно.
- Нарны цахилгаан станцаас жилд 360 сая.кВт/ц, салхин цахилгаан станцаас жилд 1,020 сая.кВт/ц-ыг нэгдсэн сүлжээнд нийлүүлнэ.
- Нэгдсэн сүлжээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ 500 МВт-аар нэмэгдэнэ.
- Эрчим хүчний импортын цахилгаан хэрэглээг бууруулж бүс нутгийн эрчим хүчний хангамж сайжирна.
- Нар, салхины эх үүсвэрээс 1 кВт.ц-ын тариф 4-5 цент буюу хямд үнэ бүхий цэвэр эрчим хүчээр хэрэглэгчдийг хангах боломжтой.
- Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 586,5 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг салхин станца 693,6 мянган тонн, нарны цахилгаан станц 244,8 мянган тонноор тус тус бууруулна.

6. “ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Төслийн явц:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 124 дүгээр “Тавантолгой цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Өмнөд бүсийн уул уурхайн болон Оюутолгой төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит “Тавантолгой дулааны цахилгаан станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан. Засгийн газрын 2020 оны 175 дугаар тогтоолоор “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн нийт хувьцааны 51 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 19 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж байна.

“Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК нь төслийг эхлүүлэхэд шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл холбогдох судалгаа тооцоолол, зөвшөөрөл, техникийн нөхцөл, газар эзэмших эрх авах зэрэг бэлтгэл ажлуудыг бүрэн хангасан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 132 дугаар “Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тогтоолоор төслийг 300МВт+150МВт гэсэн 2 үе шатад хуваан, эхний ээлжид 300МВт-аар төслийн барилга угсралт болон санхүүжүүлэх эх үүсвэрийг хамтатган (EPC+F) хэлбэрээр зохион байгуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. Тус тогтоолын хүрээнд төслийн гүйцэтгэгч, санхүүжүүлэгчийг сонгон шалгаруулах EPC+F нөхцөлтэй тендерийг 2023 оны 06 дугаар сарын 12 өдөр зарлаж, Үнэлгээний хорооны эцсийн шийдвэрээр 2023 оны 10 дугаар 26-ны өдөр тендер хүчингүй болсон тухай мэдэгдлийг оролцогчдод хүргүүлсэн. Төслийн тендерт оролцогч талуудын зүгээс анхан, дунд шатны шүүхээс гарсан шийдвэрүүд дээр Дээд шатны шүүхэд гомдол гаргасан ба Дээд шүүхийн 2024.10.22-ны өдрийн хурлаар Хяналтын шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Төсөлд хийгдэх гол ажлууд:

Тавантолгойн дулааны цахилгаан станц төслийн нь зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж худалдан авах, барилга угсралтын ажил, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, туршилт тохируулга хийх, станцын гадна дэд бүтэц байгуулах үндсэн ажлуудаас бүрдэх бөгөөд төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдсанаас хойш бүтээн байгуулалтын ажил 36 сарын хугацаанд үргэлжилнэ.

Төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг 2024 оны эхний улиралд багтаан хэрэгжүүлж, 2025 оны I улирлаас газар шороо, барилга угсралтын ажлыг эхлүүлж 2028 оны I улиралд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Төслийн I үе шат 2025-2028 он

2025 онд

- Төслийн EPC+F гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулна.
- Станцын зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлнэ.
- Станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.
- Станцын үндсэн болон туслах тоног төхөөрөмжийн захиалга хийгдэнэ.

2026 онд

- Станцын барилга угсралтын ажил үргэлжилнэ.
- Тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч, угсралт суурилуулалтын ажлыг эхлүүлнэ.
- Цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.
- Станцын ус хангамжийн системийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

2027 онд

- Станцын барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажил үргэлжилнэ.
- Цахилгаан дамжуулах агаарын шугамыг ашиглалтад оруулна.
- Станцын ус хангамжийн системийг ашиглалтад оруулна.
- Станцын туршилт тохируулга, төслийг хүлээж авах ажил хийгдэнэ

2028 онд

- 300МВт-ын хүчин чадалтай, станцын 2 блокийг ашиглалтад оруулж төвийн бүсийн нэгдсэн сүлжээ болон Оюутолгой төсөлд цахилгаан эрчим хүч нийлүүлнэ.

Төслийн ач холбогдол:

- Тавантолгой дулааны цахилгаан станц 300МВт-ын хүчин чадлаар ажиллахад 2028 оноос Монгол Улсын Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 1.88 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх ба үүнээс Оюутолгой уурхайг 1,3 тэрбум кВт.цаг, Өмнийн бүсийн уул уурхай, аж ахуй, айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангана.
- Тавантолгойн 300МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц жилд 7096 цаг ажиллахад 1 кВт.ц цахилгаан үйлдвэрлэх өөрийн өртөг 6.82 цент/кВт.ц буюу өнөөгийн импортын цахилгааны үнээс 1.4 дахин бага үнэтэй эрчим хүч үйлдвэрлэх ба төслийн дотоод өгөөжийн хувь нь 15.9 хувь байна.
- Тавантолгой дулааны цахилгаан станц нь өөрийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлогоос төсөлд зарцуулсан хөрөнгө оруулалтыг 8 жилийн хугацаанд нөхөх ба түүнээс хойш 25 жилийн хугацаанд жил бүр 90-100 сая.ам долларын цэвэр ашигтай ажиллах эдийн засгийн тооцоолол хийгдсэн. Төслийн ирээдүйд олох энэхүү ашиг нь “Эрдэнэс Тавантолгой ХК”-аар дамжуулан ард иргэдийн хүртэх нэгж хувьцааны ноогдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх юм.
- Говийн бүсийн стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, тэдгээрийг дотоодын эрчим хүчний системээс хангаж, импортын эрчим хүчний хэрэглээг хязгаарлан жилд 120-140 сая ам.долларын гадагш чиглэсэн валютын урсгалыг дотооддоо үлдээж, улс болон орон нутгийн төсөвт жилд 34.5 сая ам.долларын татвар, хураамжийг төвлөрүүлнэ.
- Ашиглалтад орсны дараа байнгын 220 ажлын байр бий болно.

7. ТАВАНТОЛГОЙ УТП - ТАВАНТОЛГОЙ КОКС ХИМИЙН ЦОГЦОЛБОР

Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрээс гарч буй баяжмалыг цаашид боловсруулж эрчим хүч, кокс, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх кокс- химийн болон кокс-эрчим хүчний үйлдвэр, дулааны цахилгаан станц, давирхай болон хий боловсруулах үйлдвэрүүд мөн сэргээгдэх эрчим хүчний нөөц, эх үүсвэрийг ашиглах нар, салхины эрчим хүчний үйлдвэр, хаягдал бүтээгдэхүүн ашиглах үнс иж бүрэн боловсруулах, ус цэвэршүүлэх үйлдвэрүүдийг Тавантолгой УТП-ийн төслийн хүрээнд үе шаттайгаар бүтээн байгуулахаар төлөвлөсөн. Ингэснээр металлургийн үйлдвэрлэлийг эх орондоо хөгжүүлэх, улмаар гарган авсан коксыг өндөр үнэтэйгээр экспортлох боломж бий болгохоос гадна коксын үйлдвэрлэлийг дагалдан хөгжүүлэх шаардлагатай химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг бий болгох юм.

КОКС-ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭР/КОКС ХИМИЙН ҮЙЛДВЭР

Түүхий эд

Эрдэнэс Тавантолгой ХК нь дээрх нөөцөд тулгуурлан жилд 20 орчим сая тн коксжих болон эрчим хүчний нүүрс олборлож байна. Жилд 10 сая тонны хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр байгуулж 2024 оны 7 сард ашиглалтад оруулаад байна. Ингэснээр кокс-эрчим хүчний үйлдвэрийг түүхий эдээр хангах боломжийг бүрдүүлэхээс гадна баяжуулах үйлдвэрээс гарсан мидлингийг шинээр байгуулах цахилгаан станцад ашиглах болно. Кокс эрчим хүчний үйлдвэр нь 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж 2 сая тонн кокс боловсруулж, 1.7 МВт эрчим хүч үйлдвэрлэнэ.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Нүүрсний баяжмалыг боловсруулж 1. Кокс үйлдвэрлэх, дайвар бүтээгдэхүүнийг ашиглаж эрчим хүч боловсруулах кокс-эрчим хүчний үйлдвэр, 2. Нүүрсний баяжмалыг боловсруулж кокс, дайвар бүтээгдэхүүн болох хий, давирхай үйлдвэрлэх кокс-химийн үйлдвэрийг бүтээн байгуулна. ТЭЗҮ болон БОНБУ зэрэг судалгаануудад үндэслэн аль үйлдвэрийг түрүүлж бүтээн байгуулахыг шийдвэрлэнэ.

1. Кокс эрчим хүчний үйлдвэр

- 2.0 сая тн кокс

80–25 мм-ийн хэмжээтэй 1.7 сая тн кокс

25–10 мм-ийн 308.9 мян.тн;

<10мм-ийн 20.6 мян.тн металлургийн кокс үйлдвэрлэнэ. Коксын бүтээгдэхүүнийг Дархан УТП-ийн төмрийн үйлдвэрт түүхий эд болгон хангаж, экспортолно.

- Кокс үйлдвэрлэх явцад ялгарсан хий, давирхай зэрэг дайвар бүтээгдэхүүнийг ашиглан 886 сая кВт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж Төвийн бүсийн ЭХС-д нийлүүлнэ.

2. Кокс химийн үйлдвэр

- 2.0 сая тн кокс

80–25 мм-ийн хэмжээтэй 1.67 сая тн кокс

25–10 мм-ийн 190.5 мян.тн;

<10мм-ийн 12.5 мян.тн металлургийн кокс үйлдвэрлэнэ.

Коксын бүтээгдэхүүнийг Дархан УТП-ийн төмрийн үйлдвэрт түүхий эд болгон хангаж, экспортолно.

- 327 сая Н.м3 хий

- 60 мян.тн давирхай үйлдвэрлэж

Хий болон давирхайг цаашид гүн боловсруулалт хийж 18.8 мян.тн битум, 12 мян тн бензин, 35.5 мян тн дизель, 100 мян. тн аммиакийн шүү үйлдвэрлэнэ.

Кокс үйлдвэрлэх технологийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага

Ерөнхийдөө өндөр температурын коксжуулах технологи нь уламжлалт буюу дайвар бүтээг- дэхүүн (By-product coke oven/Non-recovery coke oven) үйлдвэрлэх батарейд түшиглэсэн кокс- химийн үйлдвэрийн технологи болон дулаан сэргээх (Heat recovery coke oven) төрлийн батарейд түшиглэсэн кокс-эрчим хүчний үйлдвэр гэсэн хоёр үндсэн чиглэлд хөгжиж байна. Технологийн хөгжил, боломж, зах зээлийн эрэлт, хэрэгцээ, байгаль орчин, хууль эрх зүйн шаардлага, эдийн засгийн үр ашгаас шалтгаалан коксын үйлдвэрээс гарч буй дагавар бүтээгдэхүүн болох хий, давирхайг ихэвчлэн дулаан, эрчим хүчний зориулалтаар ашиглаж ирсэн. Орчин үед технологи хөгжиж, химийн үйлдвэрлэлийн түүхий эдийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь кокс-эрчим хүчний үйлдвэрлэлээс кокс-химийн үйлдвэрлэлд шилжих хандлага бий болгосон.

Кокс-химийн үйлдвэрийн кокс-эрчим хүчний үйлдвэрээс ялгарах давуу тал нь өндөр температурын коксжуулалтын процессын үед ялгарах хий, өндөр температурын давирхай зэрэг дагалдах бүтээгдэхүүнийг боловсруулж төрөл бүрийн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж химийн үйлдвэрлэлийн түүхий эдийг дотооддоо хангах боломжийг бүрдүүлэхээс гадна коксоос ялгарах үнэ цэнэтэй коксын хийгээр химийн бүтээгдэхүүн боловсруулж ашиглах явдал юм. Урьдчилсан байдлаар харьцуулалт хийж үзэхэд нүүрс-эрчим хүчний үйлдвэрийн хувьд үйлдвэр барих, хөгжүүлэхэд харьцангуй бэлэн байдал хангагдсан, технологи болон ашиглалтын хувьд хялбар энгийн, үйл ажиллагааны тал дээр эрсдэл багатай юм. Харин кокс-химийн үйлдвэрийн хувьд эрчим хүчний хэрэглээнд коксыг боловсруулахад гарч байгаа бүтээгдэхүүнийг ашиглах нь эдийн засгийн хувьд үнэ цэнийг алдагдуулахаар, өөрөөр хэлбэл химийн үйлдвэрийн дагалдах үйлдвэрлэл, бүтээгдэхүүн бий болсноор химийн үйлдвэрлэл хөгжинө.

Ингэснээр өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, хувийн хэвшил, ЖДҮ-ийг дэмжих боломжийг бүрдүүлнэ. Нарийн технологи шаардах тул үйл ажиллагааны эрсдэл өндөр, дагалдах химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хамт явагдах учир хөрөнгө оруулалт өндөр, технологи, үйл ажиллагааны хувьд нийлмэл, төвөгтэй зэрэг сул, давуу талууд байгаа. Иймд кокс эрчим хүч болон кокс химийн үйлдвэрүүдийн ТЭЗҮ, БОНБУ зэрэг судалгаануудад үндэслэн аль чиглэлээр ямар технологийг ашиглахыг эцэслэн шийдвэрлэнэ.

Төслүүдийн судалгаа

Компанийн стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж буй А6/20 хөтөлбөрт Кокс, эрчим хүчний үйлдвэрийн төсөл тусгагдсан бөгөөд олон улсын мэргэжлийн зөвлөх компани John T Boyd-ын хөндлөнгийн хараат бус техникийн тайлангийн хүрээнд 2020 онд Shanxi Zhongxin Clean Coal Technology Design institute Co., LTD Кокс-эрчим хүчний үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан.

Кокс эрчим хүчний үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ийг Белохоризонт ХХК 2023 онд, БОНБУ-ийг Хатан далай ХХК 2022 онд тус тус боловсруулж хийсэн.

Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны 10-р сарын 10-ны өдрийн А-136 тушаалаар байгуулагдсан Багануур ҮТП, Тавантолгой ҮТП-ийн төслүүдийн технологийн судалгааг эдийн засгийн тооцооллын хамт боловсруулж дүгнэлт гаргах Ажлын хэсэг нүүрсийг гүн болвсруулах зорилтын хүрээнд Багануур, Тавантолгойн ордын нүүрсний онцлогт тохирсон технологиудыг судалж, боломжилт хувилбарыг эрэмбэлж, эдгээр ҮТП-д баригдах үндсэн үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийн ажлын даалгаврыг боловсруулж 2025 онд ТЭЗҮ болон бусад шаардлагатай судалгааг хийлгэхээр төлөвлөн ажиллаж байгаа ба 2028 онд үйлдвэрийг бүтээн байгуулж ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.

Кокс эрчим хүчний үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд

Хүчин чадал

Металлургийн кокс сая тн/жил		2.0	/II зэрэглэлийн кокс/
85–25мм	мян.тн/жил	1729.8	84%
25–10мм	мян.тн/жил	308.9	15%
<10мм	мян.тн/жил	20.6	1%
Дагалдах бүтээгдэхүүн			
Цахилгаан эрчим хүч		сая кВт*цаг	886.0 Дотоод хэрэглээ 9%

Түүхий эд

Нүүрсний баяжмал мян.тн/жил		2764.2	Чийг 10%
		2487.7	Хуурай
Коксын үйлдвэрийн ус	мян.тн/жил	178.9	Шинээр сэлбэх ус
Эрчим хүчний үйлдвэрийн ус	мян.тн/жил	262.5	
Унд ахуйн хэрэгцээний ус	мян.тн/жил	30.5	
Цахилгааны хэрэглээ		сая кВт.цаг	107.2 8760 цаг
Ажиллах хугацаа	Хоног	365	Тасралтгүй 24 цаг 8760 цаг
Үйлдвэрийн талбай		Га	61.4
Ажиллах хүч		Хүн	466
Нийт хөрөнгө оруулалт		сая ам.доллар	438.7
IRR	%	18.3	
Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа			5 жил
NPV10%		сая ам. доллар	2661.2

7.2 “БАГАНУУР ҮТП” НҮҮРС-ХИМИЙН ЦОГЦОЛБОР

Багануурын хүрэн нүүрсний орд бүхий Нялга-Чойрын нүүрсний сав газрыг түшиглэн “Эрчим хүч, Нүүрс-химийн цогцолбор” олон улсын жишигт нийцсэн, өндөр технологид суурилсан нүүрс-химийн загвар үйлдвэрлэл, технологийн парк.

Байрлал: Улаанбаатар хот, Багануур дүүргийн нутаг

Бэлэн байдал:

- ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан

Хийгдэж буй ажлууд:

- ТЭЗҮ боловсруулж байна.

Шийдвэрлэх асуудал:

- Эрчим хүчний асуудал

Нийгэм, эдийн засгийн үр ашиг:

Нялга-Чойрын сав газрын хүрэн нүүрсийг боловсруулан байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, өндөр технологид түшиглэсэн загвар үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрчим хүч, хатуу, хийн болон шингэн түлш, аж үйлдвэрийн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орчны бохирдол бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд голлох нөлөө үзүүлнэ.

Уурхайн техник тоног төхөөрмжийг сайжруулж, уул геологийн ажлыг эрчимжүүлснээр олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Поролиз, нүүрс-химийн үйлдвэр байгуулж 1 сая тонн хагас кокс, дайвар бүтээгдэхүүн болох нийлэг хий, нам болон дунд температурын нүүрсний давирхай үйлдвэрлэнэ. Эдгээр үйлдвэрээс гарах бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулснаар устөрөгч, нафта (шууд нэрлэгийн бензин), дизель түлш, нийлэг байгалийн хий (SNG), меанол, диметилийн эфир (DME), олефин зэрэг төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

8. ЭРДЭНЭТ ҮТП - ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа 2050” буюу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.14-д “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барьж, байгуулна” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Уул уурхай-металлурги химийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн цогцолбор /зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр/-ыг байгуулах” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 10-д “Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна” гэж, мөн хөтөлбөрийн 1.3.3.2.-т “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 3.3.6-д “Орхон аймагт Зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна” гэж тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна” гэж тусгагдсан.

ЗЭС БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР БАРЬЖ БАЙГУУЛАХ ГАЗРЫН БАЙРШЛЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ

2011 онд тухайн үеийн Төрийн өмчийн хороо, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг “Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалыг эдийн засгийн үр ашигтай боловсруулах технологийг сонгох судалгаа”-г хийж, “Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалыг пирометаллургийн технологиор боловсруулах, тус үйлдвэрийг Орхон аймагт барьж байгуулах нь зүйтэй” гэсэн дүгнэлт гаргаж байсан.

1. 1993 он ЯПОН-JICA-ийн Эрдэнэт уурхайн шинэчлэл, хөгжлийн хөтөлбөрийн судалгааны тайлан

- Хайлуулах үйлдвэрийн байршлыг сонгох нөхцөл нь инженерийн шугам сүлжээ, түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зай, цаг агаарын нөхцөл байдал, засвар үйлчилгээний цехийн ашиглалт болон бусад хүчин зүйлээс хамаарна
- Эдийн засгийн хувьд бүтээгдэхүүний зах зээлд ойр байхын тулд дайвар бүтээгдэхүүн хүхрийн хүчлийн зах зээлийг анхаарах,
- Аж үйлдвэрийн цогцолбор байдлаар байгуулах,

2. 2013 он ЯПОН-JICA-ийн Монгол дахь зэс үйлдвэрлэлийн салбарын судалгааны тайлан

- Зэсийн баяжмалыг боловсруулахад эдийн засгийн хувьд ашигтай байх хамгийн бага хүчин чадалтай үйлдвэр нь 100 000 тн/жилд дээш байна
- Дан ганц боловсруулах үйлдвэр байгуулах нь эдийн засгийн хувьд ач холбогдол багатай, тиймээс катодын зэсийг ашиглан дараагийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэх шаардлагатай

3. 2014 он EMC-ЗБХБҮ-ийн урьдчилсан ТЭЗҮ-д тусгасан голлох асуудал

- SKS технологи нь техник технологийн үзүүлэлтээр бусад тэргүүлэх технологиудтай адил бөгөөд хөрөнгө оруулалт, ашиглалтын зардлаар харьцангуй бага
- Хүхрийн давхар исэл агуулсан хийг битүүмжлэн боловсруулах явцад нийт хүхэр барилт 96-98% байхаар тооцсон.
- Элементийн хүхэр үйлдвэрлэх хувилбар нь Монгол улсын нөхцөлд илүү тохиромжтой.

4. 2016 он КАНАД-NATCN-Байршил сонгоход ашигласан гол үзүүлэлт

- Шаардлага хангахуйц хүчдэл бүхий цахилгаан эрчим хүчний хангамж
- Шаардлага хангахуйц хэмжээ бүхий усан хангамж
- Үндсэн түүхий эдийн тээвэрлэлт, бүтээгдэхүүний тээвэрлэлт
- Тухайн байршил дахь ажиллах хүчний байдал, мэргэжлийн түвшин

Эрдэнэт ҮТП байгуулагдсанаар нийт 1300 орчим ажлын байр бий болно. Эдгээр ажлын байрны 65% нь Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрт хамаарч байна. Нийгэм эдийн засгийн тооцооллын үр дүн нь тухайн паркт хэрэгжих боломжтой шинэ шинэ төслүүдийн ашигт ажиллагаанаас шалтгаалж, тасралтгүй өсөн нэмэгдэх бүрэн боломжтойн дээр ажлын байр нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах хэв шинжийг бүрдүүлэх, гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татах, урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн бодит хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бий болгоно.

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫГ ТҮШИГЛЭН БАЙГУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЗЭСИЙН БАЯЖМАЛ ХАЙЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ-2022 ОН

Төслийн хүчин чадал

Катодын зэс 120,000.0 тн/жил

Зэс хайлуулах технологи

SKS-хайлуулалт

Үйлдвэрэлийн хүчин чадал

А зэрэглэлийн катодын зэс- 124,116.16 тн/жил

#1 стандарт катодын зэс-1,428.77 тн/жил

Алтан гулдмай (99.99%)- 72.00 кг/жил

Мөнгөн гулдмай (99.99%)- 38,189.00 кг/жил

Хүхэр- 181,962.30 тн/жил

Шингэрүүлсэн хүхрийн хүчил (10%)- 118,227.00 тн/жил

Эрчим хүчний хангамжийн индексүүд

Суурилуулсан хүчин чадал- 62,414 кВт

Тоног төхөөрөмжийн тооцоолсон ачаалал- 34,977 кВт

Жилийн эрчим хүчний хэрэглээ- 214,416 мян.кВт цаг

Нэгж зэс бүтээгдэхүүний цахилгааны зарцуулалт- 1,471 кВт цаг/тн·Cu

Усан хангамж

Нийт усны хэрэглээ- 116,850 м3/хон

Нэгж зэс бүтээгдэхүүний цэвэр усны зарцуулалт- 9.32 м3/тн

Усыг дахин хэрэглэх хувь- 97.16%

Ажиллах хүчин

Ажилчдын тоо- 853 хүн

Нийт цалин хөлс- 13,902 мян.ам.дол/жил

Хөрөнгө оруулалт

Нийт хөрөнгө оруулалт- 762,255.12 мян.ам.дол

Үүнд: Үндсэн хөрөнгийн зардал- 650,398.00 мян.ам.дол

Барилгын ажлын хугацаан дахь хүү- 18,234.12 мян.ам.дол

Ажлын капитал- 93,623.00 мян.ам.дол

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр- 762,255.12 мян.ам.дол

Үүнд: Өөрийн хөрөнгөөр санхүүжих-306,976.52 мян.ам.дол

Урт хугацаатай зээл санхүүжих-455,278.6 мян.ам.дол

Үйл ажиллагааны орлого, ашиг, татвар

Үйл ажиллагааны орлого -1,113,655.99 мян.ам.дол/жил

Татварын өмнөх ашиг- 75,337.6 мян.ам.дол/жил

Орлогын татвар- 18,526.6 мян.ам.дол/жил

Татварын дараах ашиг - 56,811.1 мян.ам.дол/жил

Эдийн засгийн үр ашгийн индексүүд

Төслийн хөрөнгө оруулалтын өгөөж

Дотоод өгөөжийн хувь, IRR-10.71%

Цэвэр өнөөгийн үнэ цэнэ, NPV(Ic=6%) 283,321.96 мян.ам.дол

Цэвэр өнөөгийн үнэ цэнэ, NPV(Ic=8%) 139,753.77 мян.ам.дол

Цэвэр өнөөгийн үнэ цэнэ, NPV(Ic=15%) -138,254.56 мян.ам.дол

Хөрөнгө оруулалтыг эргэн төлөгдөх хугацаа- 7.7 жил

9. ДАРХАН УТП - ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гангийн үйлдвэр нь хаягдал төмөрт суурилсан цахилгаан нуман зуухны технологитой МУ-ын анхны ган хайлах үйлдвэр юм. Үйлдвэрийн хүчин чадал 100.0 мян.тн цувимал бүтээгдэхүүн. Ашиглалтад орсноосоо хойш хүчин чадлын 76-30 хувьд ажиллаж байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн эзэмшилд MV-013851 тоот Хуст-Уул, MV-013319 тоот Төмөртэй, MV-010738 тоот Төмөртолгой гэсэн гурван төмрийн хүдрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл байдаг.

- **1990.04.14:** Тухайн үеийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1990 оны 04-р сарын 14-ний 160 дугаар тогтоолоор Монгол, Япон улсын засгийн газар хоорондын гэрээний дагуу, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн “Техник засварлах, металл боловсруулах үйлдвэрийн асуудал эрхэлсэн комисс” -ын харьяалал доор Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг байгуулахаар шийдвэрлэсэн.
- **2005.07.07:** МУИХ-ын 2005 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл” батлах тухай 48 дугаар тогтоолын 13.1.8. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ-ын гадаад зээлийн өрийн үлдэгдлийг баталгаажуулан, үлдэгдлийн дүнгээр буцаан төлөлтийн гэрээ байгуулсны дараа олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахаар шийдвэрлэсэн.
- **2010.12.29:** МУ-ын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай” 343 дугаар тогтоолоор Технологийн шинэчлэл хийх замаар Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг жилд 500 мянган тонн ган төмөр, бүтээц үйлдвэрлэх хүчин чадалтай болгон өөрчлөх ажлыг зохион байгуулж, түүхий эдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төмөртолгойн төмрийн хүдрийн олборлолт, боловсруулалтыг сайжруулан, хүдэр хайлах, төмөр ялган авах технологи нэвтрүүлэх болон шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх талаар тодорхой санал боловсруулах чиглэл өгөгдсөн.
- **2014.02.28:** МУ-ын Засгийн газрын 2008 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн хорооны даргын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 333 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн “Кью Эс Си” ХХК-ийг “үйлдвэр болон ил уурхайд зэрэг хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, мөн тус үйлдвэрийн эзэмшлийн төмрийн хүдрийн ордуудаас болон “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн хувьцаанаас ямар нэг хувь эзэмшихгүй, үндэсний компани” гэсэн үндэслэлээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг концессын гэрээгээр хувьчлах сонгон шалгаруулалтад санал болгосон дүгнэлтийг үндэслэн МУ-ын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн концессын гэрээг байгуулах эрхийг Эдийн засгийн хөгжлийн сайдад олгож, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг концессын гэрээний хугацаанд “Кью Эс Си” ХХК-д шилжүүлэх үүрэг, даалгаврыг холбогдох газруудад өгсөн.
- **2014.04.15:** Төрийн өмчийн хорооны 2014 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 155 дугаар тогтоолоор “Дархан Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-д шилжүүлсэн.

- **2021.12.30:** МУИХ-ын “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.2.2. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлж ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах тухайд “Төмрийн хүдрийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болох 350 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Монгол ган цогцолбор I”, 500 мянган тонн ширэм, 1 сая тонн кокс үйлдвэрлэх Алтанширээт аж үйлдвэрийн парк, 200 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр төслүүд хэрэгжиж дууссанаар 2025 он гэхэд дотоодын гол нэрийн ган бүтээгдэхүүний /арматур гэх мэт/ хэрэгцээний 80 хувийг хангаж, экспортод гаргах бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн байна” гэж тусгасан.
- **2022.04.13:** Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Концессын гэрээ цуцлах тухай” 148 дугаар тогтоол болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-аас буцаан шилжүүлэн авах тухай” 123 дугаар тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн концессыг хүчингүйд тооцож төрийн өмчид буцаан авах шийдвэр гарсан.
- **2022.11.30:** МУ-ын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах арга хэмжээний тухай” 429 дүгээр тогтоолоор тус үйлдвэрийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулах, төрийн өмчийн хувьцаа эзэмшлийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийг тогтоох, төрийн өмчит хувьцаат компанийн дүрэмд зохих өөрчлөлт оруулж, стратеги болон бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн батлах талаар болон зардал бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр удирдлага, зохицуулалтын зохих арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах тухай шийдвэр гарсан.
- **2024.08.27:** МУИХ-ын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын хавсралт-1 “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд дараах 14 мега төсөл”-ийн 11. Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана гэж тусгасан.

Одоогоор энэхүү 1 сая тонн ган бэлдэц үйлдвэрлэх Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн төслийн ТЭЗҮ болон бусад судалгаа хийгдээгүй.

Урьдчилсан судалгаагаар гаргасан Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн төслийн үндсэн үзүүлэлтүүд

Нойтон баяжуулах үйлдвэр

- Төслийн хүчин чадал- Төмрийн баяжмал -2.3 сая.тн/жил
- Түүхий эдийн хэмжээ- Төмрийн хүдэр 3.75 сая.тн/жил
- Баяжуулах технологи- Нойтон соронзон баяжуулалт болон флотаци
- Усны хэрэглээ-1.6 сая.м3

Хорголжийн үйлдвэр

- Төслийн хүчин чадал- Хорголж-1.8 сая.тн/жил
- Түүхий эдийн хэмжээ- Төмрийн баяжмал 2.4 сая.тн/жил, Бентонит 36.0 мян.тн, Битумт нүүрс-95.0 мян.тн
- Хорголж үйлдвэрлэх технологи- Эргэх хоолойт босоо зуух
- Усны хэрэглээ-0.66 сая.м3

Ширэм хайлах үйлдвэр

- Төслийн хүчин чадал- Цутгуурын ширэм-200.0 мян.тн/жил, Ган бэлдэц-500.0 мян.тн/жил, Арматур-300.0 мян.тн/жил, Лист-40.0 мян.тн/жил, Ган утас-40.0 мян.тн/жил, Хэлбэрт ган 40.0 мян.тн/жил, Зам төмөр-80.0 мян.тн/жил
- Түүхий эдийн хэмжээ- Хорголж 1.665 сая.тн/жил
- Усны хэрэглээ-1.2 сая.м3

Ган хийцлэлийн үйлдвэр, Тусгай зориулалтын ган хайлах,цувих үйлдвэр

- Төслийн хүчин чадал- Төмөр хашаа-15.0 мян.тн/жил, Автомашины ган хавтан-100.0 мян.тн/жил, Автомашины тоног төхөөрөмжийн эд анги -10.0 мян.тн, Салхийн сэнсний анкер, гинж, татлага-5.0 мян.тн
- Түүхий эдийн хэмжээ- Ган бэлдэц-115.0 мян.тн/жил, лист-10.0 мян.тн/жил, Ган утас-3.0 мян.тн/жил, Хэлбэрт ган 2.0 мян.тн/жил
- Усны хэрэглээ-0.12 сая.м3
- Цахилгааны хэрэглээ 18.0 сая.кВт.цаг

Ажиллах хүчин

Ажлын байр- 1580 хүн

Хөрөнгө оруулалт

Нийт хөрөнгө оруулалт- 655.80 сая.ам.дол

Үйл ажиллагааны орлого, ашиг, татвар

Нийт борлуулалтын орлого -5,599.15 сая.ам.дол

Цэвэр ашиг, 15%- 839.87 сая.ам.дол

Эдийн засгийн үр ашгийн индексүүд

Хөрөнгө оруулалтыг эргэн төлөгдөх хугацаа- 10.3 жил

Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, лист төмөр, ган утас, хэлбэрт ган, рейлс төмөр зэрэг эцсийн ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэснээр 2027 он гэхэд дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдэнэ. Дархан УТП-ийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх, дагаж хөгжих жижиг, дунд үйлдвэрүүдийг төр ба хувийн хэвшил, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан байгуулна. Эхний ээлжид 100.0 мянган тн хүчин чадалтай шууд ангижруулах төмрийн үйлдвэрийг барьснаар “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааг тогтвортой болгож, цаашлаад 1.2 сая тн ган хайлуулах үйлдвэрийг барьж байгуулахаар төлөвлөж байна.

Дархан УТП-ийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэйн уурхайн 220.8 сая тн төмрийн хүдрийн нөөцөд тулгуурлан нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэр, ган хайлах үйлдвэр, хүчил төрөгчийн конвертор, цутгуурын ширэмний үйлдвэрүүдийг байгуулан кластер хэлбэрээр хөгжүүлэхээр төлөвлөөд байна. Төмөртэйн ордоос жилд 3.8 сая тн төмрийн хүдэр олборлон баяжуулж 2.3 сая тн баяжмал, мөн тооны хорголжийг үйлдвэрлэх ба үүнээс 144.5 мян.тн хорголжийг 100.0 мян.тн хүчин чадалтай шууд ангижруулсан төмрийн үйлдвэрт, үлдсэн 2.15 сая тн хорголжийг Бор-Өндөр УТП-аас нийлүүлэх 200.0 мян.тн хорголжтой нийлүүлэн 1.2 сая тн хүчин чадалтай домен зууханд хайлан 200.0 мян.тн цутгуурын ширэм гарган, үлдсэн 1.0 сая тн-ыг хүчилтөрөгчийн конвертроор дамжуулан 1.0 сая тн ган, ган бэлдэц, 300.0 мян.тн арматур, 40.0 мян.тн лист, 40.0 мян.тн ган утас, 40.0 мян.тн хэлбэрт ган, 80.0 мян.тн зам төмөр зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ. Мөн гарсан бүтээгдэхүүнийг цааш нь эцсийн бүтээгдэхүүн болгон хувиргах төмөр хийцийн үйлдвэр, тусгай зориулалтын ган үйлдвэрлэх үйлдвэр, авто машин, техник, тоног төхөөрөмжийн эд анги үйлдвэрлэх үйлдвэр, ган татлага ба гинжний үйлдвэр, салхин сэнсний анкер ба төмөр каркасны үйлдвэр зэрэг дагаж хөгжих үйлдвэрүүдийг хувийн хэвшилтэй хамтран байгуулна.

Кластер үйлдвэрүүдийн хүрээнд 1274 хүний шууд ажлын байр бий болох бөгөөд 4714 хүний амьдралын чанарт дам нөлөө үзүүлнэ.

Кластер үйлдвэрүүд ба дэд бүтцийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 655.8 сая ам.доллар бол арван жилийн хугацаанд олох борлуулалтын орлого 5,599.15 сая ам.доллар байх урьдчилсан тооцоо хийгдээд байна. Эдгээр үйлдвэрүүд ашиглалтад орсноор энэ төрлийн бүтээгдэхүүнүүдээс хамаарах гадагшаа чиглэсэн валютын урсгалыг хязгаарлах, зарим төрлийн нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнүүдээс нэмэлт экспортын орлого олох боломжтой болох юм. Мөн тусгай зориулалтын ган үйлдвэрлэх, техник, тоног төхөөрөмжийн эд анги хийх өндөр технологиудыг Монгол оронд нутагшуулах, мэргэжилтэй өндөр түвшний боловсон хүчийг үе шаттайгаар бэлтгэх зэргээр хар металлургийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна.

10. АЛТ ЦЭВЭРШҮҮЛЭХ ҮЙЛДВЭР

Байрлал: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт

Бэлэн байдал:

- Төслийн ТЭЗҮ-г БНКаЗУ-ын “Сымбат инженеринг” ХХК боловсруулсан хэдий ч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулсан “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” ажлын хэсэг тус ХХК-ийн боловсруулсан 81.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүхий ТЭЗҮ-ийг хянаж үзээд “ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх” шийдвэрийг гаргасан.

Хийгдэж буй ажлууд:

- Төслийн хөрөнгө оруулалтын асуудал 2024 оны байдлаар шийдэгдээгүй 2022-2024 онд үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэх асуудал:

- 2025 онд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг шинэчлэхээр тусгаад байна.

Нийгэм, эдийн засгийн үр ашиг:

Алт цэвэршүүлэх үйлдвэр манай улсын хувьд эдийн засгийн төдийгүй үндэсний аюулгүй байдлын ач холбогдолтой. Тиймээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2019 оны 2 дугаар сард зөвлөмж гаргасны дагуу стратегийн ач холбогдол бүхий төслийн жагсаалтад оруулсан.

Монгол улсын эрдэнэсийн санг арвижуулах, гадаад валютын улсын нөөц нэмэгдүүлэх, төгрөгийн ханш тогтворжуулахад чухал үүрэгтэй.

Өнөөдрийг хүртэл гадаадын улс орнуудад алт, мөнгө цэвэршүүлж, боловсруулж, тээвэрлэж, даатгуулж байгаа зардлыг цогцоор нь хэмнэх, улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зэрэг нийгэм, эдийн засгийн үр ашигтай.

Алт цэвэршүүлэх үйлдвэрийг дотооддоо байгуулж ашиглалтад оруулснаар Монгол Улсын газрын хэвлий доорх алт, мөнгө, үнэт металлыг өөрсдөө боловсруулж, дэлхийн стандартад нийцсэн алтан болон мөнгөн гулдмай, бэлэг дурсгалын гулдмай, үрэл, ялтас зэрэг цэвэршүүлсэн бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэж эхлэх юм

Манай улс ОХУ, Их Британи, Япон зэрэг улсад алтаа цэвэршүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Швейцарь улсад цэвэршүүлж байна. Ингэж цэвэршүүлж байгаа алтны боловсруулалт, тээвэр, даатгал, хамгаалалтын зардал өндөр байхаас гадна дотоодоо олборлон баяжуулж байгаа алт нь дунджаар 85.0 хувийн агуулгатай бөгөөд түүнийг олон улсын зах зээлд борлуулахын тулд 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай байгаа юм.

11. ОРХОН-ОНГИ, ХЭРЛЭН-ТООНОТ УС ДАМЖУУЛАХ ХООЛОЙГ БАРИХ ТӨСӨЛ

Монгол орны агаарын дундаж хэм сүүлийн 80 жилд 2.25 хэмээр дулаарсан нь дэлхийн дунджаас даруй хоёр дахин өндөр байна. 2020 онд хийсэн цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Мөн сүүлийн 30 жилд мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрч байгаа нь цөлжилтийн үндсэн шалтгааны нэг болж байна.

Дэлхийн дулаарлын нөлөөгөөр Монгол орны томоохон голуудын урсац эрс багасаж, жижиг гол, горхи, нуур цөөрөм ширгэж, голуудын эрэг татам дагуух экологийн тэнцвэрт байдал алдагдаж, хуурайшилт хүчтэй явагдаж байгаа тул экосистемийг тэтгэх үндсэн нөхцөл болох усны нөөцийг хуримтлуулж гадаргын усыг ашиглах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

11.1 “ХЭРЛЭН-ТООНО” ТӨСӨЛ:

Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төслийн хүрээнд “Бүс нутаг хооронд ус тээвэрлэх боломжийн судалгаа, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэсэн нэртэйгээр 2013-2014 онд “Монхидроконстракшен” ХХК техник, эдийн засгийн үнэлгээг боловсруулсан.

Үүнээс хойш ямар нэгэн судалгаа нэмж хийгдээгүй бөгөөд 2017 онд Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийх тухай Засгийн газрын 232 дугаар тогтоол гарч Хэрлэн гол дээр боомт байгуулж хиймэл нуур буюу усан сан үүсгэх тохиромжтой газрын судалгааг Хэрлэн-Улаан үзүүр, Хэрлэн-Тооно уул гэсэн 2 газарт судалгаа хийж Хэрлэн-Тооно уулыг сонгосон.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Тооно уулын дэргэд 2400 м урт, 40 м өндөр шороон боомт байгуулан 1.6 тэрбум.м³ багтаамжтай усан сан үүсгэнэ. Усан сан үүссэнээр 6-7 МВт хүчин чадал бүхий усан цахилгаан станц байгуулж жилд 35.0-40.0 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжтой.

Нуур байгуулагдсаны дараа жил бүр 120–130 сая.м³ усыг олон зориулалтаар авч ашиглах боломжтой болно. Сайншандын аж үйлдвэрийн парк хүртэл 235 км урт, 800 мм-ийн диаметртай хос зөөлөн ширмэн хоолойгоор 2 удаа өргөж хүргэнэ.

“Хэрлэн-Тооно” усан цогцолборын төслийг хэрэгжүүлснээр Хэрлэн голын олон жилийн дундаж урсцын 5-9%-ийг усан сангаас авч битүү хоолойгоор дамжуулан Монгол орны зүүн өмнөд говьд орших Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал, аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг чанар сайтай усаар бүрэн хангана. Мөн Хэнтий аймагт 5000 га хүртэл усалгаатай тариалан эрхлэх, Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрт 80 гаруй тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

“Хэрлэн-Тооно” төслийн нийт хөрөнгө оруулалт 1.6 их наяд төгрөг болно.

Хэрлэн-Тооно төслийн хувьд ТЭЗҮ-ийн тодотгол, ажлын зураг төсөл, төсөв хийх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэхээр “Эрдэнэс-Оюутолгой” ХХК-тай хамтран хэрэгжүүлэхэд эхний ээлжинд нэн шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн. “Оюутолгой” ХХК нь Хэрлэн-Тооно төслийн ТЭЗҮ-ийн тодотгол хийхэд /3сая.доллар/-ын санхүүжилтийг шийдвэрлэсэн. Хэрлэн-Тооно ТЭЗҮ тодотгол хийх тендерийг 2024.07.02-нд зарлаж, 2024.08.20-нд нээсэн. Уг тендэрт 3 компани материалаа ирүүлсэн бөгөөд 2024.08.26-нд үнэлгээний хороо хуралдан тендерийг үнэлж, “Монхидроконстракшн” компанийг хамгийн сайн тендер ирүүлснээр шалгаруулан мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 01-нд уг ажлыг хийхгэрээ байгуулсан. Хэрлэн гол дээр ус хуримтлуулах усан сан байгуулж, урсцын тохируулга хийн, ус дамжуулах хоолойгоор дамжуулан Говийн бүсэд шинээр байгуулах хот суурин, хүн ам, мал аж ахуй, газар тариаланг усаар хангах, байгаль экологийг нөхөн сэргээх хамгаалах зориулалтаар ашиглах, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон асуудлуудыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэх юм.

11.2 “ОРХОН-ОНГИ” ТӨСӨЛ:

Онги голын эх орчмын экосистемд нөлөөлж буй хүчин зүйлсийн 79.6% нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэсэн судалгааны үндсэн дээр Онги голын урсцыг тэтгэх Улаан нуурыг сэргээх, хүн ам, газар тариалан, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэх хэрэгцээг хангахад шаардагдах гадаргын усыг хуримтлуулж, ашиглах Орхон-Онги төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2019-2020 онд боловсруулж Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төв, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Усны нөөцийн зөвлөлөөр батлуулсан.

Тус төслийн хүрээнд 663 сая м³ эзлэхүүнтэй ус хуримтлуулах 2 усан сан барих ба Орхон голоос Мандал-Овоо сумын Улаан нуур хүртэл 307 км ус дамжуулах далд шугам хоолойг 5-8 жилд барьж байгуулах бөгөөд 873.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.

Экологийн төслийн үр ашгийг дээшлүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор өмнийн говийн бүсийн уул уурхайн өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангах зорилгоор Мандал-Овоогоос Таван толгой хүртэлх 202 км хоолой барихад 267.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна. Тус бүс нутагт дахь нийт усны эрэлт нь 2019 онд 20.61 сая.м³/жил байсан бол 2030-2050 онд 3.3- 3.4 дахин өсөх тооцоо гарсан ба төсөл хэрэгжсэнээр жилд 12.8-25.2 сая.м³ усыг өмнөд говийн бүс рүү дамжуулж, гадаргын усаар хангах боломж бүрдэнэ.

Төсөл хэрэгжсэнээр Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны төвшин тогтворжиж, нийгмийн хувьд Онги голын дагуу оршин сууж буй 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах боломж бүрдэх юм. Түүнчлэн агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал бүхэлдээ сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулан өнөө болон ирээдүй хойч үеийнхний сайн сайхны төлөө эерэг олон үр дүнг бий болох бөгөөд төслийн нийт өртөг 1.1 их наяд төгрөг болно.

ОНГИ ГОЛЫН УРСЦЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ - “ОНГИ-ЦАГААН БУРГАСТАЙ” УСАН ЦОГЦОЛБОР

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-д “Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжын ажлыг эхлүүлнэ гэж тусгасан.

Цаашид бид Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, уур, амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны нөөцийн хомстол, шар шороон шуурганы эсрэг тэмцэж буй бодлого, зорилт, арга барил, хандлагаа эрс өөрчлөн, бодитой үр дүнд хүрэхийн тулд экосистемийг тэтгэх үндсэн нөхцөл болох усны нөөцийг хуримтлуулж, гадаргын усыг ашиглах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Судалгаагаар Онги голын эх орчмын экосистемд нөлөөлж буй хүчин зүйлсийн 79.6% нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байна. Иймд Онги голын урсцыг тэтгэх Улаан нуурыг сэргээх, хүн ам, газар тариалан, эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэх хэрэгцээг хангахын тулд гадаргын ус хуримтлуулж, ашиглах Онги төслийн техник эдийн засгийн үндэслэлийг 2019-2020 онд боловсруулж БХБЯ-ны Барилгын хөгжлийн төв, БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөлөөр батлуулаад байна.

Тус төслийн хүрээнд **65 сая м³** эзлэхүүнтэй ус хуримтлуулах 1 усан сан барих ба Онги голоос Мандал-Овоо сумын Улаан нуур хүртэл **236 км** ус дамжуулах далд шугам хоолойг **3-5 жил** барьж байгуулахад **416.3 тэрбум** төгрөг /122.4 сая.ам доллар/ шаардагдахаар байна. Үүнд:

1. Ажлын зураг төсөл, БОННУ-ний ажил

А. Ажлын зураг төсөл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх

Б. Ус нийлүүлэх, дамжуулах хоолойн ажлын зураг хийх, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажлын зардалд нийт **4.0 тэрбум** төгрөг

2. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт Онги-Цагаан бургастай усан цогцолборын усан сан-26 м өндөр, 700 м урт шороон боомт барихад 65 сая.м³ усыг хуримтлуулна. Усан санг ашиглан 0.25-0.5 мВт хүчин чадалтай УЦС байгуулах боломжтой. Нийт хөрөнгө оруулалт **26.1 тэрбум** төгрөг;

3. Цагаан бургастайн усан сангаас Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онгийн хийд хүртэл 156 км урттай ус дамжуулах далд хоолойн зардал **251.1 тэрбум** төгрөг;

4. Онгийн хийдээс Мандал-Овоо хүртэл 80 км урт хоолойгоор дамжуулж Онги голд ус нийлүүлэх байгууламжийн хөрөнгө оруулалт **135.1 тэрбум** төгрөг;

Төсөл хэрэгжсэнээр Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны төвшин тогтворжиж, нийгмийн хувьд Онги голын дагууд оршин сууж буй 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал бүхэлдээ сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж цөлжилтийг бууруулж өнөө болон ирээдүй хойч үеийнхний сайн сайхны төлөө эерэг олон үр дүнг бий болгох юм.

“Онги-Цагаан бургастай” усан цогцолборын хүрээнд 65 сая.м³ эзлэхүүнтэй ус хуримтлуулах усан сан барих ба Онги голоос Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дахь Улаан нуур хүртэл 236 км ус дамжуулах далд шугам хоолойг барьж байгуулна.

Төсөл хэрэгжсэнээр Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны төвшин тогтворжиж, нийгмийн хувьд Онги голын дагууд оршин сууж буй 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал бүхэлдээ сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж цөлжилтийг бууруулж өнөө болон ирээдүй хойч үеийнхний сайн сайхны төлөө эерэг олон үр дүнг бий болгох юм.

Голын урсцыг тасралтгүй жигд хэмжээтэй нэмэгдүүлэх нь нуга, татмын өвслөг ургамлын биомасс, ургац нэмэгдэж хадлан авах, тариалан эрхлэх боломжийг бүрдүүлнэ. Биологийн олон янз байдал сэргэж, цаашид урт хугацаанд хадгалагдах нөхцөл үүснэ. Усан сан үүссэнээр усны шувуудын хувьд амьдрах орчны таатай нөхцөл бий болох, идэш тэжээлийн хүртээмж сайжрах эерэг нөлөөтэй. Ус дамжуулах байгууламж дагуу мал, амьтны усалгаа хийх боломжийг бүрдүүлснээр гантай жилд эергээр нөлөөлнө. Усан сангийн чийглэг орчинд шавж, шумуул ихэснэ.

Говийн бүс нутаг дахь эдийн засгийн хөгжил, хуурайшилтыг багасгах, нэмэлт усны нөөц нь хот суурин газар руу чиглэх хүн амын төвлөрөлтийг багасгах, хүн ам, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах усны хэрэглээг хангах, отор нүүдлийг багасгах олон талын ач холбогдолтой. Энэ нь хөдөөгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулахад хувь нэмэр оруулна. Гол дагуух суурьшил нэмэгдэх боломж бүрдсэнээр газрын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар газар ашиглалтын төлбөр, татварын орлогыг нэмэгдүүлнэ.

12. МОНГОЛ-ФРАНЦЫН ХАМТАРСАН “УРАН ОЛБОРЛОХ” ТӨСӨЛ

Байрлал: Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт

Бэлэн байдал:

- Зөөвч-Овоо ураны ордын үйлдвэрлэлийн туршилтын ажил 2,7 жил хүлээгдсэний эцэст 2021 оны 07 дугаар сарын 11-ний өдөр ажлаа эхлүүлж, 2022 оны 12 дугаар сард дуусгасан.
- Зөөвч-Овоо ордод явагдсан үйлдвэрлэлийн туршилтаар ураныг газрын дор уусган олборлох технологиор олборлон нийт 10.5 тонн цэвэр уран бүхий 27.5 тонн эцсийн бүтээгдэхүүн /шар нунтаг/ олборлож 4 контейнер 123 торх ураны баяжмал (аммонийн ди-уранат) төслийн талбайд хадгалагдаад байна.

Хийгдэж буй ажлууд:

Одоогоор энэхүү төсөл ашиглалтад бэлтгэгдэж ордын Үндсэн олборлолтын үйл ажиллагааг 2028 оноос эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд бэлтгэл ажлууд хийгдэж байна.

- Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах
Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг “Орано” группийн Монгол Улсын Цөмийн Энергийн Комиссын дарга Л.Энх-Амгаланд 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр албан ёсоор хүргүүлсэн. Одоогийн байдлаар хэлэлцээний шатанд явагдаж байна.
- Техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол боловсруулах
- Зөөвч-Овоо, Дулаан-Уул ордуудыг ашиглах 2015 онд батлагдсан Техник, эдийн засгийн үндэслэлд нэмэлт, тодотгол хийж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр 2020 оны 07 дугаар сард хүргүүлсэн боловч үйлдвэрлэлийн туршилтын дараа хэлэлцэхээр төслийг буцаасан. Зөөвч-Овоо, Дулаан-Уул ураны ордуудыг ашиглах Үйлдвэрлэлийн туршилтыг 2022 оны 12 дугаар сард дуусган үр дүнг холбогдох төрийн байгууллага болон, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд танилцуулсан байна. Тус ТЭЗҮ-ийн тодотгол нь ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар 2023 оны 06 дугаар сар, 2023 оны 12 дугаар сард тус тус хэлэлцүүлэгдэж буцаагдсан бөгөөд уг ТЭЗҮ-ийн шинжээчдийг ахин томилуулж, ажиллаж байна.

Шийдвэрлэх асуудал:

- Хамтарсан “Бадрах Энержи” ХХК нь Зөөвч-Овоо, Дулаан-Уул ураны ордуудыг газрын доор уусган олборлох технологиор ашиглана. Туршилтаас гарсан үр дүнд үндэслэн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулснаар 2025 оноос үндсэн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг эхлүүлэх нарийвчилсан инженерийн зураг төсөл хийлгэхээр төлөвлөж байна.

Нийгэм, эдийн засгийн үр ашиг:

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг бий болгох нь зөвхөн Монгол Улсын төдийгүй хүн төрөлхтөний өмнө тулгарч буй эрхэм зорилт билээ.

Энэхүү зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогод нэгдэж, цөмийн эрчим хүчийг “ногоон буюу тогтвортой, цэвэр” эх үүсвэр хэмээн зарлаж байна.

Дэлхий нийтийн жишгээс үзэхэд цөмийн түлш ашиглан 1 кВт/цаг эрчим хүч үйлдвэрлэхэд нүүрс ашиглахаас 68 дахин бага хэмжээгээр хүлэмжийн хийн ялгаруулдаг бөгөөд 1 кг цөмийн түлш нь 160,000 кг буюу 4 воган нүүрсний хэрэглээтэй тэнцдэг байна.

Дэлхийн зах зээлд цөмийн түлш, ураны хэрэгцээ жил бүр тасралтгүй өсөж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 32 улс 440 цөмийн реактор ашиглаж байгаа бол шинээр барьж буй 63, барихаар төлөвлөсөн 88, ирээдүйд төлөвлөж буй 344 реактор байна.

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (IAEA) -аас ураны эрэлт 2024 онд 93 мянган тонн байгаа бол 2050 гэхэд 177 мянган тонн болж нэмэгдэх тооцооллыг гаргажээ.

Монгол Улс байгаль орчныг хамгаалах, хүлэмжийн хийг тэглэх үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор 1997 оны Киотогийн протокол, 2015 оны Парисын хэлэлцээр, 2021 оны Глазковын хэлэлцээрт тус тус нэгдэн орж, хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7%-иар бууруулах амлалтыг дэлхийн улс орнуудын өмнө хүлээгээд байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улс 192.2 мянган тонн ураны нөөц бүртгэсэн нь дэлхийн ураны нөөцийн 3 хувийг бүрдүүлж, нөөцийн хэмжээгээр дэлхийд 10-т жагсаж байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлж үндсэн үйлдвэрлэл эхэлснээр жилд 2500 тн ураныг нийт 33 жилийн хугацаанд үйлдвэрлэх ба төслийн нийт хөрөнгө оруулалт 1.6 тэрбум ам.доллар, улс, орон нутагт төлөх татвар 5 тэрбум ам.доллар, үүнээс жилд ирээдүйн өв санд 36 тэрбум доллар, хуримтлалын санд 18 сая доллар төвлөрүүлж нийт 1600 гаруй ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөж байна.

13. ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН ТУХАЙ

“Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг Энэтхэгийн инженер, мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж 2018 оны 11 дүгээр сард УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэн хүлээн авч менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2019 оны 05-р сарын 13-ны өдөр “Engineers India Limited” компанитай байгуулж, үйлдвэрийн инженерчлэл, зураг төслийн ажлыг эхлүүлсэн.

НТЭЗҮ-ийг батлуулснаас хойш 5 жил тутамд түүнийг тодотгох, шинэчлэх шаардлагын дагуу НТЭЗҮ-ийг боловсруулсан “Engineers India Limited” компани нь үйлдвэрийн технологийн зураг төсөл, техник технологийн нэмэлт өөрчлөлтүүд, цар тахалтай холбоотойгоор үүссэн дэлхийн зах зээл дээрх бараа материалын үнийн өсөлт зэрэг хүчин зүйлүүдийг авч үзэн, төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлын өөрчлөлтийг дахин тооцоолж, НТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулсан бөгөөд 2023 оны 09-р сарын 27-ны өдөр УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж баталгаажуулсан.

“Газрын тос боловсруулах үйлдвэр” байгуулах цогц төсөл нь үйлдвэрийн үндсэн технологийн байгууламжуудаас гадна цахилгаан станц, ус хангамжийн байгууламж, ачих буулгах байгууламж, агуулах сав, резервуар, түүхий тос дамжуулах хоолой, төмөр зам, авто замын бүтээн байгуулалтаас бүрдэнэ. Мөн үйлдвэрт ажиллагсдын амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг давхар шийдэх зориулалттай 550 айлын орон сууц, сургууль цэцэрлэг, худалдаа үйлчилгээний төв зэргээс бүрдсэн “Газрын тосны үйлдвэрийн хотхон” багтах юм.

2024 оны 09 дүгээр сарын байдлаар ЕРС 01 багцын ажил дуусаж, Улсын комисс хүлээж авах шатандаа явж байгаа бол ЕРС 02, ЕРС 03 багцын ажлууд хэрэгжилтийн шатандаа явж байна. ЕРС 04 багцын ажлыг үргэлжлүүлэхэд 431 сая ам.долларын нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон тул нэмэлт санхүүжилтийн хүрээнд Энэтхэгийн “Экзим” банктэй гэрээ байгуулахаар хүсэлт хүргүүлсэн. Технологийн байгууламжуудын барилга угсралтын ажлын (ЕРС-2,3) Ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилан сонгон шалгаруулалт явагдаж байна. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил (төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам)-ын ажил хийгдэж дууссан. Одоогоор инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажил үе шаттайгаар хийгдэж байна.

Тамсаг XXI болон Тосон-Уул XIX талбайн газрын тосыг боловсруулж, шингэрүүлсэн шатдаг хий, бензин, дизель түлш, онгоцны түлш болон зуухны түлшийг үйлдвэрлэн гаргана.

Дээрх хоёр талбайн түүхий тос нь дэлхийд олборлож буй бусад газрын тостой харьцуулахад, хоёулаа хөнгөн, хүхрийн найрлага бага, хүчлийн тоо бага (TAN), парафины агуулга болон царцах хэм нь өндөр тоснууд юм. Тухайлбал, олон улсын газрын тосны бирж дээр борлуулагдаж буй Брент маркийн түүхий тос 0,45% -ийн хүхэртэй байхад Монголд олборлож буй газрын тос нь 0,11% хүхрийн агуулгатай байна. Газрын тос дахь хүхрийн хэмжээг тодорхойлох нь чухал ач холбогдолтой бөгөөд учир нь хүхрийн нэгдлүүд нь газрын тосны бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж, үйлдвэрийн боловсруулах байгууламжийн катализаторыг хордуулж, шатах явцад хүрээлэн буй орчныг бохирдуулах хийг ялгаруулдаг байна.

Үйлдвэрт боловсруулагдах тосны хүчлийн агуулга бага байгаа нь үйлдвэрийн байгууламжид ашиглагдах материалын зардлыг хэмнэх сайн талтай юм. Нафтагийн фракцийн шинжилгээний аргаар тогтоосон октаны тоо бага тул изомержүүлэх болон реформингийн байгууламжуудын тусламжтайгаар октаны тоог дээшлүүлэн, АИ-95 төрлийн бензинийг үйлдвэрлэн гаргана.

Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Дорнод аймгийн Матад, Халх гол сумдын нутаг дэвсгэрт орших Тамсагийн сав газарт байрших газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д олгох тухай тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Технологийн бус байгууламжийн (ЕРС-1) ажлын гэрээг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулж, ажлыг 2021 оны 3 дугаар сард эхлүүлсэн.

Хүчин чадал

Жилд 1.5 сая тн газрын тос боловсруулах үйлдвэрлэл /Евро-5 стандарт/

Автобензин 339 мян.тн

Дизель түлш 824 мян.тн

Онгоцны түлш 80 мян.тн

Шингэрүүлсэн шатдаг хий 43 мян.тн

Зуухны түлш 47 мян.тн

Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

Бүтээн байгуулалтын хугацаанд 6000 хүнийг ажлын байраар хангана.

Цаашид үйлдвэрт 600 тогтмол ажлын байр бий болно.

Түлш, шатахууны импортын хамаарлаас гарна.

Шатахууны үнэ импортын шатахуунаас 15-20 хувь хямд байх боломж бүрдэнэ.

Нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар бий болно.

Шатахууны дотоодын хэрэгцээний 55-60 хувийг хангана.

Гадаад худалдааны алдагдал \$1.0 тэрбум орчмоор буурна.

14. ҮНДЭСНИЙ ХИЙМЭЛ ДАГУУЛ

Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулыг хөөргөснөөр Монгол Улсын газар нутгийг бүрэн хамарсан, орон зайн ялгаваргүй харилцаа холбооны бие даасан сүлжээ үүсгэж интернэт суурьтай бүх төрлийн харилцаа холбооны үйлчилгээг бүх иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх боломжийг нээж өгнө.

Түүнчлэн зөвхөн шилэн кабелийн сүлжээнээс хамаарсан интернэтийн гарцын эрсдэлийг бууруулах, онцгой байдлын үед байнгын харилцаа холбоотой байх, гамшиг ослын эрсдэлийг бууруулах, хот хөдөөгийн иргэдийн тоон ялгааг арилгах, хөдөө, орон нутгийн иргэд, малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цахим сургалтад хамрагдах боломж олгоно үзэж байна.

Үндэсний хиймэл дагуул хөөргөснөөр:

- Гамшгийн ослоос шалтгаалж амиа алдах хүмүүсийн тоог 30 хувь бууруулна;
- Агаарын бохирдлыг хэмжинэ;
- Зудын гамшиг 10 хувь буурна;
- Ой хээрийн түймэр 10 хувь багасна;
- Алслагдсан бүс нутгийн эрүүл мэндийн зардал 10 хувь буурна;
- Боловсролын ялгаа 50 хувиар багасна гэж тус тус үзэж байна.

Үндэсний хиймэл дагуулыг 36,000 км-т хөөргөхөөс гадна дөрвөн ширхэг газрын антен суулгаснаар өөрсдөө хиймэл дагуулаа удирдах боломжтой болно.

Өнгөрсөн хугацаанд Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас сансар дахь байршлыг гурван удаа баталгаажуулсан бөгөөд 2027 онд хиймэл дагуулаа бүтээж дуусган, сансрын уудам орон зайд гаргахаар төлөвлөсөн.

Мөн жил бүр транспондер түрээслэн телевиз, интернэт, хөдөлгөөнт холбооны сүлжээ, харилцаа холбооны үйлчилгээг алс зайд дамжуулахад ашиглахад гаргаж байгаа зардлыг хэмнэж, дотоодын зах зээлд үлдээх боломж бүрдэнэ.

Түүнчлэн онцгой байдал, хил хамгааллын харилцаа холбоо сайжирч, гамшиг, ослын улмаас үүдэх хүний амь нас, эд хөрөнгөнд учрах хохирлыг бууруулдаг судалгаа байдаг бөгөөд цахим засаглалын тоон дэд бүтэц сайжирч, аж үйлдвэрлэлийн бүх салбарт цахим шилжилтийг эрчимжүүлж, шилэн кабелийн сүлжээ хүрээгүй алслагдсан багуудын тоон хуваагдлыг багасгаж, орон зай, байршлаас үл хамаарсан боловсрол, цахим эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх боломж бүрдэнэ гэж тооцсон.

№	Төсөл, арга хэмжээ		Төсөвт өртөг /сая төгрөг/	Хариуцах яам	Төслийн нэгж	ТЭЗҮ гүйцэтгэгч	Үндсэн гүйцэтгэгч	ТЭЗҮ-ийн байдал
14 МЕГА ТӨСӨЛ								
1	“Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, "Шивээхүрэн-Сэхээ" хилийн боомтуудын хил дамнасан төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина.	"Гашуунсухайт-Ганцмод"	868,589.00	ЗТЯ			Чайна Энержи ХХК	ТЭЗҮ-2023 (бэлэн) БОННУ-2023 зураг төсөв 2024
		“Ханги-Мандал”	498,662.50	ЗТЯ				ТЭЗҮ-2020 (бэлэн) БОННУ-2020 зураг төсөв 2022
		"Шивээхүрэн-Сэхээ"	207,667.10	ЗТЯ				ТЭЗҮ-2020 (бэлэн) БОННУ-2020 зураг төсөв 2022
2	Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг барина.		2,865,735.60	ЭХЯ	Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ		ТЭЗҮ-2023 (бэлэн) БОННУ-2019
3	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.		1,173,100.00	ЭХЯ	Эрдэнэбүрэнгийн УЦС ТӨХХК	Пауэр Чайна Ченгду	Пауэр Чайна Ченгду болон Пауэр Чайна	ТЭЗҮ-2019, БОННУ-2021 (бэлэн)
4	Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц барина.		3,700,000.00	ЭХЯ	Эгийн голын УЦС ТӨХХК	Трактабел инженеринг		ТЭЗҮ-2014 (бэлэн) БОННУ-2014
5	Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ.		2,500,000.00	ЭХЯ				Шинээр боловсруулах шаардлагатай

6	Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах хоолойг барих төслийг хэрэгжүүлнэ.	Хэрлэн-Тооно	1,600,000.00	БОУАӨЯ	Усны төслүүдийн нэгж	Монхидро констракшн ХХК		ТЭЗҮ-2020-2021 (бэлэн)
		Орхон-Онги	1,100,000.00	БОУАӨЯ	Усны төслүүдийн нэгж	Престиж инженеринг ХХК		
7	Эрэнцав-Чойбалсан-Баруун-Урт-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина.		7,400,000.00	ЗТЯ				Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт ТЭЗҮ 2013 онд хийгдсэн; Чойбалсан-Бичигт ТЭЗҮ боловсруулж байна
8	Монгол, Францын хамтарсан Ураны төслийг хэрэгжүүлнэ.		5,443,104.10	АҮЭБЯ	Бадрах Энержи ХХК	Мон-Атом ХХК	Бадрах Энержи ХХК	ТЭЗҮ-тэй (бэлэн)
9	Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна.	Нүүрс-хими	408,000.00	АҮЭБЯ	Эрдэнэс ҮТП	Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв ХХК		Шинээр боловсруулна
		Кокс-хими	2,347,360.00	АҮЭБЯ	Тавантолгой ҮТП төслийн нэгж			Шинэчлэх шаардлагатай
10	Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна.		2,591,820.00	АҮЭБЯ	Зэс боловсруулах цогцолбор ХХК	Чайна Энфи инженеринг		Тодотгох шаардлагатай
11	Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна.		2,229,720.00	АҮЭБЯ	Дархан ҮТП төслийн нэгж			Шинэчлэн боловсруулна

12	Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна.	7,179,000.00	АҮЭБЯ	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	Мегха инженеринг	Мегха инженеринг	ТЭЗҮ-тэй (бэлэн)
13	Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.	-	АҮЭБЯ				Шинэчлэх шаардлагатай
14	Үндэсний хиймэл дагуулыг хөөргөнө.	1,108,434.00	ЦХХХЯ				ТЭЗҮ-тэй (бэлэн)
Нийт		43,221,192.30					